

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 6 дугаар сарын 3-ны өдөр

Дугаар 76

Улаанбаатар хот

**УЛСЫН МӨРДӨН БАЙЦААХ БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ ТАЛААР АВАХ ЧИГЛЭЛ ӨГӨХ
ТУХАЙ**

Улсын мөрдөн байцаах байгууллагыг бэхжүүлэх талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай:

1)улсын мөрдөн байцаах байгууллагыг үйл ажиллагааны хувьд бие даалган хараат бус байдлыг хангах асуудлыг судалж, тогтолцоог нь боловсронгуй болгох арга хэмжээг энэ оны III улиралд багтаан авч шийдвэрлэх;

2)улсын мөрдөн байцаах байгууллагыг төсөв хөрөнгө, техник хэрэгсэл, ажиллах нөхцөлөөр хангах арга хэмжээг тусгайлан боловсруулж хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах нөхцөлийг бүрдүүлэх;

3)улсын мөрдөн байцаах байгууллагын ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх тогтолцоог буй болгож ажиллагсдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авах.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ П.ОЧИРБАТ**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД П.ЖАСРАЙ**